



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалтыг үндэслэн, эдийн засгийн нөхцөл байдал, үнэт цаасны компаниудын санхүүгийн чадварыг харгалзан ТОГТООХ нь:

**Нэг.** Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8 дугаар хавсралтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8 дугаар хавсралт

“ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ:

- 1) Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 30,0 сая төгрөг;
- 2) Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг;
- 3) Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа – 200,0 сая төгрөг;
- 4) Андеррайтерийн үйл ажиллагаа – 1,000,0 сая төгрөг;
- 5) Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 6) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 7) Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 8) Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 9) Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/ – 1,000,0 сая төгрөг.”

**Хоёр.** Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлсэн байхыг үнэт цаасны зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлэгчдэд үүрэг болгосугай. */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 387 дугаар тогтоолоор өөрчилсөн/*

**Гурав.** Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоосон хугацаанд хангаагүй брокер, дилерийн компанийн харилцагчдыг зохих журмын дагуу өөр үнэт цаасны компанид шилжүүлэхийг анхааруулсугай.

**Дөрөв.** Энэхүү тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/, Хянан шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА